

УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

Кубын хувьсгалын 25 жилийн ойд

КУБЫН ХУВЬСГАЛЫН ТҮҮХТ ОЙ

Б. Батболд

Түүхийн ухааны дэд эрдэмтэн

1984 оны нэгдүгээр сарын 1-нд Кубын ард түмэн өөрийн үндэсний баяр—Кубад хувьсгал ялсны 25 жилийн ойг зөвлөлтийн ард түмэн, ах дүү социалист хамтын нөхөрлөлийн орнууд болон дэлхийн дэвшилт улс түмний хамтаар ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлээ. Куба түмэн энэ түүхт ойгоо тэмцэл, ялалтын бадрангуй амжилтаар угтав.

1959 оны 1-р сарын 1-нд Кубын ард түмний гарамгай хүү Фидель Кастро тэргүүтэй эх орончдоор удирдуулж, нийт хөдөлмөрчин ард түмний дэмжлэг, талархлыг хүлээсэн босогчдын арми америкийн империализмын гар хөл болсон Батистын дарангуйлагч дэглэмийг түлхэн унагааж, кубын ард түмэнд жинхэнэ эрх чөлөө, тусгаар тогтнолыг олгосноос хойш 25 жил өнгөрлөө.

Олон улсын коммунист, ажилчны намуудын Москвагийн зөвлөлгөөний үндсэн баримт бичигт тэмдэглэсэнчилэн: «Кубын хувьсгал бол Латин Америкт империалист төрийг байгуулах нөхцөл бүрдүүлсэн нь түүхэн эргэлт болж тэнд хувьсгалт хөдөлгөөний шинэ үе шатыг нээсэн юм».¹

Латин Америк дахь хувьсгалт үйл явцын өнөөгийн өрнөлтөд Кубын хувьсгалын ялалт зоригжуулагч жишээ болж байна.

Кубын ард түмэн эхлээд олон зуун жилийн турш испанийн колоничлогчдын эсрэг дараа нь өнгөрсөн зууны эцсээс АНУ-ын империализмын түрэмгийлэл, дарлалын эсрэг эрэлхэг тэмцэл явуулж ирсэн түүхтэй билээ. Хүн төрөлхтний түүхэнд эргэлтийн үе болсон аугаа их Октябрийн социалист хувьсгал кубын ард түмний тэмцэл, Куба орны цаашдын хувь заяанд шийдвэрлэх нөлөө үзүүлсэн юм.

Дэлхийн социалист систем үүсэн тогтож энэ нь үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний хүчирхэг тулгуур болсны үр дүнд империализмын хараат байсан бага буурай Куба орон АНУ-ын улс төр, эдийн засаг, цэргийн их хүчийг сөрөн эсэргүүцэж Кубын эх орончид хувьсгалт тэмцлээ ялалтанд хүргэн, ард түмнээ үндэсний болон нийгмийн дарлалаас эгнэт чөлөөлж, түүнд жинхэнэ эрх чөлөөг олгосон билээ.

Хувьсгалын өмнөх Куба орны үндэсний бүх баялаг, байгалийн арвин нөөц гадаадын, гол төлөв АНУ-ын томоохон хөрөнгөтний мэдэлд байсан бөгөөд Кубын ард түмний хөдөлмөрийн үр шимийг гадаадын болон үндэсний баячуул, том газрын эзэд латифундууд сорон мөлжиж байв.

¹ «Коммунист, ажилчны намуудын олон улсын зөвлөлгөөний баримт бичгүүд», УБ., 1969. 34-р тал

Ажилгүйдэл, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл, өлсгөлөн гуйланчлал, бичиг үсэг үл мэдэх явдал зэрэг хөрөнгөтний нийгмийн салшгүй хөнөөлт үр дагавар Куба орныг хүчтэй нөмөрсөн байлаа. Үндэсний эрх ашгаас урван тэрслэгч, америкийн империализмын дуулгавартай зарц болсон Батистын харгис дэглэм 1952 онд Кубад тогтсон нь тус орны доторхи нийгмийн зөрчлийг улам хурцатгасан юм. Харгис дарангуйлалын эсрэг хөдөлгөөн хот, хөдөөгүй өрнөж, түүнд ажилчин, тариачин, дэвшилт сэхээтнүүд оролцоод зогсоогүй эх оронч үзэлтэй жижиг хөрөнгөтнүүд хүртэл өргөнөөр хамрагдаж байв.

1953 оны 7-р сарын 26-нд Кубын хувьсгалч үзэлтэй эх орончид харгис дэглэмийн Монкада хуаранг довтолсон явдал Куба нутгийн гэрэлт ирээдүйн төлөө явуулсан хувьсгалт тэмцлийн эх үндэс болсон юм.

1983 оны 7-р сард Сантьяго-Куба хотод болсон Монкадагийн ХХХ жилийн ойд зориулсан баярын цуглаан дээр нөхөр Ф. Кастро хэлсэн үгэндээ «30 жилийн өмнөх тэр өдрүүдийн үйл явдал нь 5 жил хагасын дараа буюу 1959 оны 1-р сарын 1-нд Куба эх орноо империализмын болон харгис дэглэмийн боолчлолоос бүрэн чөлөөлөх замын дайчин эхлэл болсон» гэж тэмдэглэжээ.

Ф. Кастро тэргүүтэй Кубын эх орончид 1953 онд харгис дэглэмийн цэргийн Монкада хуаранг дайрснаас хойш хувьсгалт тэмцлээ үргэлжлүүлэн тэмцсээр 1959 оны 1-р сарын 1-нд харгис Батистын дэглэмийг түлхэн унагаасан билээ. Ийнхүү дарлан мөлжигчдийн эсрэг өөрийн эх орны эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө явуулсан Кубын ард түмни тэмцэл ялж америк тивд эрх чөлөөт Куба улс хөгжил дэвшлийн цоо шинэ хуудсыг өөрийн түүхэнд анх удаа нээв.

Хувьсгалын эхний жилүүдэд хувьсгалт засгийн газар нь хуучин нийгмээс үлдсэн эдийн засгийн хоцрогдол болон дайсагнагч, хорлон сүйтгэгч үзэл суртлын нөлөө уршгийг арилгах талаар олон төрлийн эрчимтэй арга хэмжээ авсны үр дүнд Кубын ард түмэн улс орноо хөгжүүлэх үйлст сайхан амжилт олсон юм.

Кубын ялгуусан хувьсгалын нөлөө манай бөмбөрцгийн баруун хагаст, тухайлбал, Латин Америкт түгэн дэлгэрэхээс айн түгшсэн АНУ-ын болон олон улсын империалист харгис хүчин Кубын хувьсгалыг багалзуурдан дарахыг оролдон, шинэ залуу социалист улсыг ганцаардуулах түүнд улс төр, эдийн засгийн элдэв дарамт шахалт үзүүлэх, түүний эсрэг хорлон сүйтгэх, гүжирдэн гүтгэх зэрэг зүсэн бүрийн ялт ажиллагаа үйлдэж байна.

АНУ-ын империалист харгис хүчин 1961 оны 4-р сард Кубын хувьсгалын эсэргүүчүүд, хөлсний дээрэмчдийг зэвсэглэн бэлтгэж эрх чөлөөт Куба нутгийн Плайя-Хироны орчим буулган түрэмгийлэл үйлдсэн боловч Кубын ард түмэн, түүний хувьсгалт зэвсэгт хүчин дайсныг 72 цаг хүрэхгүй хугацаанд бут цохисон билээ. Плайя-Хироны энэ ялалт бол эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэж байгаа хувьсгалт хүчин ЗХУ болон социалист бусад орон, олон улсын дэвшилт хүчний зүйл бүрийн тусламж дэмжлэг, эв санааны дайчин нэгдлийн ачаар хувьсгалт ололтоо баттай хамгаалж чадсаныг дэлхий дахинд тод харуулсан нэг жишээ юм.

Кубын хувьсгал нь аливаа хувьсгал анхнаасаа өөрийгөө хамгаалах хүчин чадалтай байсан цагт жинхэнэ хувьсгал болдог гэсэн Лениний заалтын үнэн зөвийг дахин нотлов.

Коммунист нам, хувьсгалт засгийн газраа хүрээлэн нягтарсан Кубын ард түмэн, ах дүү социалист орнууд, ялангуяа ЗХУ-ын интернационалч тусламж дэмжлэгт тулгуурлан өнгөрсөн хорин таван жилийн дотор эрх чөлөөний арлын нүүр царайг үндсээр нь өөрчилж, улс ор-

ноо өндөр өгөөжтэй механикжсан хөдөө аж ахуй, аж үйлдвэр бүхий орчин үеийн шинжлэх ухаан, соёл, хөгжсөн социалист орон болгон хувиргалаа. Одоогоос 25 жилийн өмнө нишингийн ургац зонхилсон өрөөсгөл аж ахуйтай байсан Куба орон өнөөдөр нишингэ хураах комбайн, автобус, хөргөгч, телевизор, радио хүлээн авагч зэргийг өөрөө үйлдвэрлэдэг боллоо.

Олон улсын коммунист, ажилчны хөдөлгөөний нэрт зүтгэлтэн Кубын ард түмний их хүү Фидель Кастро тэргүүтэй Кубын коммунист намаар удирдуулсан Кубын ард түмэнд өнөөдөр эх орондоо социализмын материал-техникийн бааз байгуулах зорилтыг амжилтай хэрэгжүүлж байна.

Өнгөрсөн 25 жилийн дотор Куба орон нийгмийн бүхий л салбарт томоохон амжилт олов. Зөвхөн боловсролын салбар гэхэд хэрэв 1959 оны хувьсгалын ялалтын өмнө 1 сая гаруй хүн уншиж бичиж чаддаггүй байсан бол, одоо тус оронд насанд хүрсэн бүх хүмүүсийн дотор бичиг үсэг үл мэдэх явдал устаж, хуучин нийгмийн бурангуй хоцрогдлыг арилгажээ. Эдүгээ Кубын гурван хүн ам тутмын 1 нь аль нэг шатны сургуульд суралцаж байна. Хэрэв 0—5 насны хүүхдийг эс оролцуулбал хоёр хүн тутмын нэг нь сурч байгаа буюу мэдлэг боловсролоо дээшлүүлж байгаа ажээ. Өнөөгийн тоог хувьсгалын өмнөх үетэй харьцуулахад 18 дахин өсчээ.

Кубын бүх хүн амын 2 хувь нь дээд сургуульд сурч байгаа бөгөөд 1983 оны байдлаар хувьсгалын жилүүдэд дээд боловсролтой болсон хүний тоо 20 мянга гаруй болжээ.

БНКАУ ардын засгийн жилүүдэд эрүүлийг хамгаалах салбарт томоохон амжилт олсон юм. Улсын эрүүлийг хамгаалах систем ард түмэнд анагаах ухааны хамгийн орчин үеийн нарийн мэргэжлийн тусламжийг үзүүлж байна. Куба улсад сахуу, хумхаа, цагаан цэцэг зэрэг өвчний үндэс голомт устжээ. Хөдөлмөрчин олны эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн олон төрлийн урьдчилсан арга хэмжээ авч байгаагийн үр дүнд Кубын хүн амын дундаж нас 58 байснаа уртсаж 73,5 болжээ. Түүнчлэн хүүхдийн эндэгдэл эрс багасч, шинээр төрсөн нэг мянган хүүхэд тутмаас 70 нь нас барж байсан бол энэ тоо одоо 17,3 болж буурчээ.

Кубын нийгэм-эдийн засагт асар их өөрчлөлт гарсны дотор хөдөө аж ахуйн салбарт үлэмж амжилт оллоо. Хөдөө аж ахуй механикжиж, орчин үеийн техниктэй болжээ. Хувьсгалын өмнө Куба даяар дөнгөж 9 мянган трактор байсан бол эдүгээ 80 мянга гаруй болжээ.

Хөдөө аж ахуйд бордоо хэрэглэж байгаа газрын хэмжээг 1958 онтой харьцуулахад 10 дахин, усалгаатай талбай 5 дахин, усан сангийн хэмжээ 125 дахин өсжээ. Түүнчлэн элсэн чихэр, өндөг, сүү, хүнсний ногоо зэрэг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хэмжээ үлэмж нэмэгдсэн байна. Бас далай, тэнгисийн уснаас авах олзворлолт 10 гаруй дахин өсжээ.

Цахилгаан эрчим хүчний чадлыг 1953 оныхтой зэрэгцүүлэхэд 12 дахин нэмэгдэж, цахилгаан хэрэглэгчид 3 дахин өсчээ. Улсын цахилгаан эрчим хүчний шугам мөн үеийнхийг бодоход 5,5 дахин нэмэгджээ.

ЗХУ-ын тусламжтайгаар Гавана хотод барьж байгаа 1200 мегаваттын хүчин чадалтай Съенфуэгосийн атомын цахилгаан станц нь Кубын эрчим хүчний салбарын хөгжилтөд чухал ач холбогдолтой болох юм. Уул уурхайн салбарт Кубын гол баялаг болох диц ба кобальтийн үйлдвэрлэл улам бүр өсөн нэмэгдэж байна. Шинээр баригдаж байгаа үйлд-

вэр заводуудын ачаар тус орны металлын үйлдвэрлэл хоёр дахин нэмэгдэнэ. 1983 онд барилгын салбарт оруулсан хөрөнгө оруулалтыг 1958 оныхтой зэрэгцүүлэхэд 8 дахин нэмэгдсэн бөгөөд цементийн үйлдвэрлэл 1958 онд 740 мянган тонн байсан бол эдүгээ 5 сая 600 мянган тоннд хүрээд байна.

Зөвхөн эдгээр баримт бол Кубад хувьсгал ялсны ачаар тус орны улс ардын аж ахуйд гарсан ололт мөн.

Кубын эдийн засаг дахь социалист өөрчлөлтийг капиталист орнуудын санхүүгийн байгууллага болох Олон улсын Банкны мэдээнээс үзэхэд нэг хүн амд ноогдох үндэсний бүх бүтээгдэхүүний жилийн өсөлт 4,4% болж байгаа нь Латин Америкит хамгийн дээгүүрт байна. Түүнчлэн НҮБ-ийн Латин Америкийн эдийн засгийн Комиссын мэдээгээр 1970—1975 онд Латин Америкийн 19 оронд нэг хүн амд ноогдох үндэсний бүх бүтээгдэхүүний өсөлт 21% байсан бол БНКУ-д 48% байсан бөгөөд 1975—1980 оны жишээгээр энэ үзүүлэлт 33 хувиар Кубад нэмэгдэж байхад бүх Латин Америкийн хэмжээгээр 16% байсан юм.

Эдгээр тоо баримт нь Кубын ард түмэн социалист хувьсгалын ялалтын үр дүнд өнгөрсөн 25 жилийн дотор АНУ-ын империализмын тасралтгүй дэгдээж буй өдөөн хатгалга, хорлон сүйтгэх ажил явууллагын эсрэг тусгаар тогтнол, эрх чөлөө, үнэн үйл хэргийг хамгаалан социалист ололт амжилтаа аривжуулан хүн төрөлхтөний гэрэлт ирээдүй өөд итгэл төгс замнаж яваагийн тод гэрч юм.

Кубын ард түмний энэ их амжилт нь түүний нөр их хөдөлмөр, кубын коммунист намын мэргэн удирдлага, ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлтийн бусад орны ах дүүгийн сэтгэл харамгүй тусламж дэмжлэгтэй салшгүй холбоотой юм.

1980 оны 12-р сард хуралдсан Кубын коммунист намын II их хурал кубын ард түмний төрийн амьдралд чухал үйл явдал болов. Тус их хурал нь өнгөрсөн таван жилийн дүнг гаргаж социалист байгуулалт болон гадаад бодлогын цаашдын зорилтыг тодорхойлов.

Кубын ард түмэн хоёрдугаар таван жилийн төлөвлөгөөний гурав дахь жил—1983 онд нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх зорилтыг амжилттай хэрэгжүүлэв.

Энэ нь дэлхийн социализмын хүч чадлыг зузаатган бэхжүүлэх, өөрийн орны олон улсын байр суурийг бататгах, улс түмний энх тайван, аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт жинтэй хувь нэмэр болж байна.

Улс түмний эрх чөдөө, тусгаар тогтнолын үйл хэргийг хамгаалж, тэдний дотоод хэрэгт империалистүүд хөндлөнгөөс оролцохыг эсрэгүүцсэн БНКУ-ын зарчимч тууштай, интернационалч гадаад бодлого Америк тивийн анхны социалист улсыг дэлхий дахинд их нэр хүндтэй болгож байна. БНКУ нь Ази, Африк, Латин Америкийн 30 орчим хөгжиж байгаа оронд боловсрол, барилга болон эрүүлийг хамгаалах салбар тусламж үзүүлж байна. Сүүлийн үед АНУ-ын эрх баригчдаас Төв Америк болон Карибын тэнгисийн сав газрын орнуудын эсрэг явуулж буй «том бороохойн» бодлогын уршгаар 1983 оны 10-р сарын эцсээр Рейганы засаг захиргаа НҮБ-ын гишүүн бөгөөд бүрэн эрхт, тусгаар тогтносон Гренадад улсыг түрэмгийлэн эзлэж авахад Гренадад интернационалч тусламж үзүүлж байсан кубын 24 барилгач-интернационалчид амь үрэгдсэн билээ. Гренадад болж байгаа гунигт хэрэг явдалтй холбогдуулан кубын коммунист нам, засгийн газраас хийсэн мэдэгдэлд «Кубын эрэлхэг зоригтой барилгачид, бусад иргэд олон улсын эв санааны нэгдлийн үйл хэргийн түүхэнд мартагдаш-

гүй хуудас үлдээлээ. Тулалдаанд амь үрэгдсэн кубачууд, тэрчлэн империалистүүдийн хууль бусаар үйлдэж байгаа ичгүүр сонжуургүй түрэмгийллийн аюул заналаас өөрсдийн зарим, интернационалч үүрэг, эх орноо хамгаалан тэмцсэн, тэмцсээр ч байгаа бүх хүмүүсийн яруу алдар мөнх юм»² гэж тэмдэглэжээ.

1983 оны 10-р сарын 28-нд МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга нөхөр Ю. Цэдэнбал манай улсад айлчилсан БНКУ-ын ГЯЯ-ны орлогч сайд Пелегрин Торрасыг хүлээн авч уулзахаар Гренада улсын эсрэг АНУ-ын үйлдсэн зэвсэгт халдлагыг БНМАУ-ын засгийн газар, монголын ард түмэн туйлын их жигшин зэвүүцэж, хилэгнэн буруушааж байгааг илэрхийлэн «Гренадын эсрэг түрэмгийлэл нь БНКУ, Никарагуа улсын эсрэг америкийн засаг захиргааны үйлдэж байгаа адал балмад явууллагатай шууд холбоотой юм»³ гэж тэмдэглэсэн билээ.

Улс түмний эрх чөлөө, тусгаар тогтнолыг хүндэтгэн энх тайвныг эрхэмлэн үздэг монголын олон нийт Төв Америк болон Карибын сав газрын орнуудын ард түмний чөлөөлөх хөдөлгөөн, энэ бүс нутаг дахь дэвшилт өөрчлөлтийг хааж, нухчин дарах гэсэн АНУ-ын эрх баригчдын бодлогыг эрс шийдвэртэй буруушааж, балмад оролдлогоо нэн даруй зогсоохыг Рейнаны засаг захиргаанд шаардаж байна.

АНУ-ын эрх баригч бүлгийнхний милитарист жанжлах дээрэнгүй бодлогын уршгаар өнөөгийн Төв Америкийн болон Карибын сав газрын районд буй болсон хурцадмал байдал нь зөвхөн тус бүр нутгийн хувьд төдийгүй дэлхий дахины энх тайван, бүх нийтийн аюулгүй байдалд ноцтой аюул занал учруулж байна. Иймд тус бүс нутгийн байдлыг хэлэлцэн тохиролцох замаар зохицуулахад чиглэсэн БНКУ-ын засгийн газрын санал, санаачлага нь цаг үеэ олсон зөв зүйтэй энх тайванч, чухал алхам мөн.

Кубын Коммунист нам, засгийн газраас олон улсын тавцанд явуулж байгаа гадаад бодлогын чиг шугам нь дэлхийн дэвшилт олон нийтийн талархал дэмжлэгийг хүлээж байгаа бөгөөд БНКУ-ын олон улсын нэр хүндийг улам дээшлүүлж байна. 1979 онд Эвсэлд нэгдээгүй орнуудын төр, засгийн газрын тэргүүн нарын 6-р бага хурлыг БНКУ-д амжилттай зохион явуулсан нь үүний тод гэрч юм.

БНКУ нь өнөөдрийн байдлаар дэлхийн 120 гаруй оронтой дипломат, 80 гаруй улстай худалдаа, соёлын харилцаатай байгаа бөгөөд олон улсын 80 орчим байгууллагын гишүүнээр үр бүтээлтэй ажиллаж байна.

БНКУ нь ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн бусад оронтой тогтоосон тал бүрийн харилцаа, хамтын ажиллагаагаа улам бүр хөгжүүлэн гүнзгийрүүлж байна. Нэн ялангуяа Куба улс 1972 онд ЭЗХТЗ-ийн гишүүнээр элссэн цагаас хойш энэ харилцаа, хамтын ажиллагаа улам өргөжиж байгаа бөгөөд тус улс социалист интеграцийн цогцолбор программыг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож байна.

Дэлхийн социалист хамтын нөхөрлөлийн салшгүй хэсэг болсон БНМАУ, БНКУ-ын хоорондох ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагаа марксизм-ленинизм, социалист интернационализмын зарчим дээр тулгуурлан манай хоёр улсын эрх ашиг, энх тайван, нийгмийн дэвшил, социализмын тусын тулд жилээс жилд цэцэглэн хөгжиж улам шинэ шинэ хэлбэрээр баяжин бэхжсээр байна.

² «Гранма» 15. X. 1983.

³ «Үнэн» 1983.X. 28

Монголын ард түмэн, түүний засгийн газар Кубын хувьсгалын ялалтын анхны өдрөөс эхлэн кубын баатарлаг ард түмний талд бат зогсож, түүний шударга тэмцлийг ямагт дэмжиж ирсэн билээ. МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчийн дарга нөхөр Ю. Цэдэнбал манай хоёр орны найрамдалт харилцааны талаар хэлэхдээ: «БНМАУ-ын коммунистууд болон хөдөлмөрчид хувьсгалт Кубатай тогтоосон ах дүүгийн найрамдлыг маш нандигнан чин сэтгэлээс түүнд баярлаж байдаг бөгөөд манай хоёр орны хамтын ажиллагааг амьдралын бүх салбарт цуцалтгүй бэхжүүлэн өргөжүүлэх эрмэлзлэл төгс байна» гэж тэмдэглэсэн билээ.

Манай хоёр нам, орон, ард түмний ах дүүгийн найрамдал, нягт хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэн бэхжүүлэх үйл хэрэгт ККН-ын Төв Хорооны хоёрдугаар нарийн бичгийн дарга, Төрийн Зөвлөл, Сайд нарын Зөвлөлийн 1-р орлогч дарга нөхөр Рауль Кастро тэргүүтэй кубын нам засгийн төлөөлөгчдийн 1970 онд манай оронд хийсэн айлчлал болон МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга нөхөр Ю. Цэдэнбал тэргүүтэй манай орны нам-засгийн төлөөлөгчид 1972 оны эцсээр Куба улсад хийсэн айлчлал нь чухал нэмэр оруулсан юм.

Энэ хугацаанд хоёр улсын засгийн газрын хооронд худалдаа, шинжлэх ухаан- техник, соёлын талаар хамтран ажиллах хэлэлцээр, консулын конвенц байгуулагдан хэрэгжиж байна.

Монгол, Кубын ард түмний элгэн халуун найрамдал, хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэхэд Монгол-Куба, Куба-Монголын найрамдлын нийгэмлэгүүд зохих хувь нэмэр оруулж байна.

МАХН-ын XVIII их хурал дээр н. Ю. Цэдэнбал «Кубын коммунист намын шалгарсан удирдлагаар социалист ололтоо аривжуулж, америкийн империализм, олон улсын харгис хүчний өнгөлзлөгөөс ололтоо тууштай хамгаалан империализмыг эсэргүүцсэн улс түмний эрх чөлөөний хөдөлгөөний үйл хэрэгт үнэтэй хувь нэмэр оруулж байгаа Кубын ард түмний эрэлхэг тэмцлийг манай нам, монголын ард түмэн бүрэн дүүрэн дэмжиж байна»⁴ гэж тэмдэглэсэн юм.

Империализм, харгис хүчний эсрэг даян дэлхийн энх тайван улс түмний найрамдал хамтын ажиллагааны хөгжилтөд Монгол-Кубын ах дүүгийн олон талт хамтын ажиллагаа зохих хувь нэмрээ оруулж байна.

⁴ Ю. Цэдэнбал. МАХН-ын XVIII их хуралд тавьсан Намын Төв Хорооны тайлан ойрын жилүүдийн зорилт. УБ., 1981. 10-р тал.

КУБИНСКОЙ РЕВОЛЮЦИИ-25 ЛЕТ

(Резюме)

Б. Батболд к.и.н.

Настоящая статья посвящена 25-летию победы Кубинской революции, становлению новой жизни в первой латиноамериканской стране, освободившейся от эксплуатации империалистических монополий. Автор знакомит читателей с основными этапами национально-освободительной борьбы кубинского народа, с успехами трудящихся в построении социалистического общества, наиболее важными проблемами социально-экономического развития Кубы.

В статье освещаются внешнеполитическая деятельность Республики Куба, ее действия на международной арене, а также развитие Монголо-кубинской дружбы и сотрудничества.

В статье отмечается успешное развитие и укрепление уз братской дружбы, сотрудничества и боевой солидарности МНР с социалистической Кубой. Как подчеркивалось на XVII съезде МНРП «наша партия и монгольский народ всецело поддерживают дружественную борьбу кубинского народа, который под испытанным руководством коммунистической партии Кубы приумножает свои социалистические завоевания и стойко защищает их от посягательств американского империализма и международной реакции, вносит ценный вклад в дело антиимпериалистического освободительного движения народов».